



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр


Дугаар 5/14

Ховд

Т.Цэрэндуламыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Ховд аймаг дахь ажилтнаар Төмөрцогийн Цэрэндуламыг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хугацаагүй гэрээгээр томилон ажиллуулсугай.
2. Т.Цэрэндуламд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТҮ-7-1 дэх шатлал болох 703,623 төгрөг (долоон зуун гурван мянга зургаан зуун хорин гурав) -өөр цалинжуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.
3. Т.Цэрэндуламтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт даалгасугай.
4. Захирамжийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хүргүүлэн Улсын байцаагчийн эрх олгох ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 Захирал 384